**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2025 оны 06 сарын 20 өдөр — Дугаар А/423 — Булган сум

Гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн хуралдааны IV/26 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан Хяналтын камерын хүчин чадлыг нэмэгдүүлэх (Булган сум) ажлын гүйцэтгэх гүйцэтгэгчээр шалгарсан “Юнивишн” ХХК-тай 379,780,000 (гурван зуун далан есөн сая долоон зуун наян мянга) төгрөгөөр гэрээ байгуулж, холбогдох хууль, тогтоомж, гэрээний дагуу хяналт тавьж, хүлээн авахыг Аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (Б.Одхүү)-т даалгасугай.

2.Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандартын дагуу гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг “Юнивишн” ХХК-ийн захирал (Д.Жамъяншарав)-д үүрэг болгосугай.

3.Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Б.Ариунболд)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Д.ПҮРЭВ-ОЧИР

Sugar Ажил 2025 өдөр бүр Doc/2025/Захирамж

6325010599

Аймгийн Засаг даргын 2025. оны
06 дугаар сарын 20-ны/ний өдрийн
А/423 дугаар захирамжийн хавсралт

Гэрээнд тусгах нөхцөл шаардлага

| д/д | Нөхцөл шаардлага | Мөнгөн дүн | Хариуцах албан тушаалтан |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |
| 1 | Ажил гүйцэтгэх хугацаа | Хуанлийн 35 хоног | Б.Одхүү |
| 2 | Алданги | Алдангийн хувь: Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.1 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна. | Б.Ариунболд |
| 3 | Чанарын баталгаа | Гэрээний үнийн дүнгийн 5 хувь, чанарын баталгааг байршуулах банк, дансыг гэрээнд тусгана. | Б.Ариунболд<br>Б.Одхүү |
| 4 | Гүйцэтгэлийн баталгаа | Гэрээний үнийн дүнгийн 3 хувь | Б.Ариунболд |